

## **МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2024-2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг баталсан.

Коронавируст цар тахлын халдварт бүрэн дарагдаагүй байгаатай зэрэгцээд 2022 оны 2 дугаар сарын 24-нд ОХУ-Украйны нөхцөл байдал хурцдаж эхэлсэн нь дэлхий дахинд хүнс, эрчим хүчний үнийг огцом өсгөж, нийлүүлэлтийн сүлжээний тасалдлыг бий болгосноор сүүлийн 40 жил байгаагүйгээр инфляцыг хөөрөгдөж, эдийн засгийг саарууллаа.

Америк, Их Британи зэрэг хөгжингүй орнууд инфляцыг бууруулахад нэн тэргүүнд анхааран мөнгөний бодлогыг эрс хатууруулахын зэрэгцээ төсвийн бодлогыг чангаруулж байгаа нь хөгжиж буй орнуудын хувьд хөрөнгийн гадагшлах урсгалыг ихэсгэж, өрийн болон ханшийн дарамтыг эрс нэмэгдүүлж байгааг олон улсын байгууллагууд онцолж байна.

Дээрх шалтгаанаас үүдэн манай улсын инфляц 2022 оны эхний 8 сард 14.4 хувьд хүрч, төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэж 1.3 тэрбум амдолларт хүрсэн нь Засгийн газраас төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах, гадаад валютын нөөцийг хамгаалахад чиглэсэн мөнгөний хатуу бодлого болон төсвийн хэмнэлтийн бодлогыг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагыг бий болгож байна.

Иймд дээр дурдсан нөхцөл байдал, үндэслэл шаардлагын дагуу ирэх 2023 онд төрийн хэмнэлтийг хэрэгжүүлж, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг дэмжих, импортын дарамтыг сааруулах, нөөцийн оновчтой хуваарилалтаар дамжуулан макро эдийн засгийг тогтвортжуулах төсвийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтуүдийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн боловсрууллаа.

--- оОо ---